



ӨВӨГДЭЛХЭЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/27

Арвайхээр

Зардал хуваарилж, эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн 2021 оны төсөв батлах" 03/07 дугаар тогтоолын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Аймгийн 2021 оны төсөв батлах" 03/07 дугаар тогтоолын 3.1 дэх заалтад тусгагдсан сумдын төрийн албаны автомашины засвар, шинэчлэл хийх төсөл арга хэмжээний зардал 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгийг хавсралтад зааснаар зарцуулсугай.

2. Хавсралтын 2, 3 дугаарт тусгагдсан Хужирт, Гучин-Ус сумдын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдаж авах зардалд тусгагдсан тус бүр 50,000,000 (тавин сая) төгрөг, Нарийнтээл сумын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдаж авах зардалд 40,000,000 (дөчин сая) төгрөг, нийт 140,000,000 (нэг зуун дөчин сая) төгрөгийг зарцуулах эрхийг холбогдох сумдын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

3. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-д болон холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100066

Аймгийн Засаг даргын 2021 оны...
дугаар сарын...-ны өдрийн... дүгээр
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1	Нарийнтээл сумын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдаж авах	40,000,0
2	Гучин-Ус сумын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдаж авах	50,000,0
3	Хужирт сумын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдаж авах	50,000,0
4	Аймгийн Засаг даргын Тамгын газарт автомашин худалдаж авах	60,000,0
	НИЙТ ДҮН	200,000,0

-оОо-